БАТЛАВ
"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.НЯМСАМБУУ

БАТЛАВ
"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш. БАЯНМӨНХ

# "ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ" /ДСУМС/ ПРОГРАММААС ТООЛУУРЫН ЗААЛТЫН МЭДЭЭЛЭЛ АВАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр  № 2022/42 33/2022  Улаанбаатар хот

Нэг талаас "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК /цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх/-ийг төлөөлж Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ч.Нэргүй, нөгөө талаас "Амгалан дулааны станц" ТӨХК /цаашид "Үйлчлүүлэгч компани" гэх/-ийг төлөөлж Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Э.Мөнхжаргал нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ /цаашид "гэрээ" гэх/ байгуулав.

## НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Монгол Улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн "Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам" болон бусад хууль тогтоомжийн дагуу "Дамжуулах сүлжээний удирдлага мэдээллийн систем" /ДСУМС/ программаас тоолуурын заалтын мэдээллийг **фидер тус бүрээр цаг тутмын ачаалал, тоолуурын заалтыг хоногоор нэгтгэж авах** үйлчилгээний гэрээний үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгч компанийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Талууд энэхүү гэрээтэй холбоотой харилцаанд бие биенийхээ эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж, тогтвортой, харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх, найрсаг харилцааг эрхэмлэх, эрх тэгш байх, бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцох, гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх зарчмуудыг удирдлага болгоно.

1.3 Талууд тоолуурын заалтын мэдээлэл авах фидерийн тоог гэрээний хавсралтад заасны дагуу харилцан тохиролцов.

1.4 Доорх хавсралт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

1.4.1 Тоолуурын заалт авах фидерийн жагсаалт /Хавсралт №1/

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэхүү гэрээ нь 2022 оны 04 дүгээр сарын 01 -ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэл 1 (нэг) жилийн хугацаанд үйлчилнэ.

2.2. Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацаа дуусгавар болоход талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болгох саналаа бичгээр гаргаагүй тохиолдолд энэхүү гэрээг дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

## ГУРАВ. ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

3.1 Үйлчлүүлэгч компани нь нэг жилийн үйлчилгээний төлбөр болох 2 640 000 /хоёр сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгийг нэхэмжлэх, зарлагын баримт, НӨАТ-ын баримт зэргийг үндэслэн дор дурдсан хуваарийн дагуу төлнө. Дээрхи үнийн дүнд НӨАТ орсон болно.

3.1.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсанаас хойш ажлын 5 хоногт багтаан Үйлчлүүлэгч компани болох 2 640 000 /хоёр сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгийг төрийн банкны 346900248559 тоот дансанд шилжүүлнэ.

## ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үйлчилгээ үзүүлэгч компани нь дараах эрхийг эдэлнэ: Үүнд:

4.1.1 Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлүүлэх;

4.2 Үйлчилгээ үзүүлэгч компани нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1 Гэрээний хавсралтад заасан үйлчилгээг чанартай хүргэх

4.2.2 Төлбөрийн нэхэмжлэхийг факс, и-мэйл эсхүл шуудангаар хүргүүлэх

## ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Үйлчлүүлэгч компани нь дараах эрхийг эдэлнэ: Үүнд:

5.1.1 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргаж шийдвэрлүүлэх

5.2 Үйлчлүүлэгч компани нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.2.1 Үйлчилгээг зориулалтын бус аргаар эсхүл хууль бусаар ашиглахгүй байх

5.2.2. Үйлчилгээ үзүүлэгчийн программыг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү программ, үйлчилгээний нууцлалын асуудлыг Үйлчлүүлэгч компани өөрөө хариуцна.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. ХОЛБОО, ХАРИЛЦАА

7.1 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг, цахим шуудан, утсаар харилцана.

## НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

8.2 Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1 Гэрээ нь талуудын эрх, ашиг сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.

9.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

9.3 Аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр бичгээр гэрээнд хавсралт байдлаар тусгана.

9.4 Энэхүү нэмэлт өөрчлөлт бүхий хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.5 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.6 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харьцана.

9.7 Энэхүү гэрээг 4 хувь үйлдэх ба талууд тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 хувийг авна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"ЦДҮС" ХХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер

Б.Дащдаваа

Ерөнхий нягтлан бодогч

Э.Түмэнжаргал

Мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Ч.Нэргүй

Хуулийн зөвлөх

Г.Алтангэрэл

Төрийн банк
Дансны дугаар 346900248559
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 3-р хороо 45 ЦДҮС ТӨХК-ийн төв байр.

Утас: 70042939

Захиалагчийг төлөөлж:

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер

Э. Мөнхжаргал

СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн ажлыг орлон гүйцэтгэгч

Ө.Удвал

Инженерийн хэсгийн ахлах инженер

Б.Батцоож

Нэгдсэн цехийн дарга

Ж. Ариунжаргал

Хуулийн мэргэжилтэн

Г. Саруул

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 8 дугаар хороо Ботаникийн эцэс УС-15-1-1
Утас: 99021269, 99047300, 99652289
Утас:77111239, 77111257

..... тоот гэрээний Хавсралт №1

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК

| Д/д | Тооцооны дэд станцын нэр | Тооцооны фидерийн дугаар, нэр |
|---|---|---|
| 1. | "ДУЛААН" ДЭД СТАНЦ | Ячейк 10 ҮБ тэжээл-Б |
| 2. | | Ячейк 8 Вагон хөмрөгч-Б |
| 3. | | Ячейк 6 Нүүрс бутлагч-Б |
| 4. | | Ячейк 7 ҮБ тэжээл-А |
| 5. | | Ячейк 5 Нуруулдан овоологч |
| 6. | | Ячейк 3 Вагон хөмрөгч-А |
| 7. | | Ячейк 1 Нүүрс бутлагч-А |

Тоолуурын мэдээлэл /өдөр бүр/

2022.04.01

| Д/д | Нэр | Цаг | | | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 01 | 02 | 03 | ....... | ....... | 23 | 24 | |
| 1 | Ячейк 10 | | | | | | | | |
| 2 | Ячейк 8 | | | | | | | | |
| 3 | Ячейк 6 | | | | | | | | |
| 4 | Ячейк 7 | | | | | | | | |
| 5 | Ячейк 5 | | | | | | | | |
| 6 | Ячейк 3 | | | | | | | | |
| 7 | Ячейк 1 | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | |

Тайлбар: Цахилгааны ачааллыг цаг тутам, тоолуурын заалтыг 24 цагаар авна.
Мэдээллийг Ээлжийн инженер, цахилгааны инженер, тооцооны инженерт өгөх.